

ХЯНАЛТ ШАЛГАЛТАД ХЯНАЛТЫН ХУУДАС ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага нь /цаашид “хяналт хэрэгжүүлэх байгууллага” гэх/ гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналт шалгалт /цаашид “хяналт шалгалт” гэх/-д хяналтын хуудсыг хэрэглэх, шалгуулагч этгээдийн үйл ажиллагааг үнэлэх, үнэлгээг баталгаажуулах, хяналт шалгалтын бүртгэлийн нэгдсэн санд оруулахтай холбоотой асуудлыг зохицуулахад оршино.

1.2. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хяналтын хуудас боловсруулах аргачлалын дагуу боловсруулагдаж батлагдсан хяналтын хуудсыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагч /цаашид “улсын байцаагч” гэх/ нар хяналт шалгалтын үйл ажиллагаандаа хэрэглэнэ.

1.3. Хяналтын хуудас батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох асуудлыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар шийдвэрлэнэ.

1.4. Улсын /ахлах/ байцаагч нь хяналт шалгалтыг батлагдсан хяналтын хуудсанд заасан асуудлын хүрээнд хийж гүйцэтгэнэ.

1.5. Үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, тухайн байгууллагын хууль тогтоомжийн хэрэгжилтийн түвшин, хяналтын чиглэлээс хамаарч шалгуулагч этгээдэд нэг ба хэд хэдэн хяналтын чиглэлээр хяналт шалгалт хийж болно.

1.6. Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад өөрчлөлт орох тухай бүрт хяналтын хуудасыг шинэчлэн батлаж мөрдүүлнэ.

1.7. Хяналт хэрэгжүүлэх байгууллага нь хяналт шалгалт хийсэн тухай бүр хяналтын хуудсыг хяналт шалгалтын бүртгэлийн санд оруулж, тухайн салбар, байгууллагад хууль тогтоомжийн хэрэгжилт ямар түвшинд байгаа талаарх мэдээлэл, зөрчлийн түүхийг бүрдүүлнэ.

1.8. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага нь хяналтын хуудсыг иргэн, хуулийн этгээдэд сурталчилж, ил тод, нээлттэй байлгах зохион байгуулалтын арга хэмжээг авна.

1.9. Төлөвлөгөөт бус болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад хяналтын хуудас ашиглахгүй байж болно.

1.10. “Хяналтын хуудасны код” гэж хяналтын чиглэл бүрээр үйл ажиллагааг хянах хяналтын хуудсыг ялган ангилах зорилгоор өгсөн дугаарыг нэрлэнэ. “Хяналтын хуудас” гэж хяналт шалгалтын болон шалгуулагч этгээдийн талаарх ерөний мэдээлэл, хяналт шалгалт хийх явцад тухайн байгууллагын хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа түвшинг тогтоох хяналт шалгалтын асуултууд, хууль тогтоомж зөрчигдсөнөөс гарч болох эрсдэлийг үнэлж, тодорхойлох зэрэг өгөгдлүүдээс бүрдсэн үнэлгээний хуудсыг хэлнэ. Хяналтын хуудас нь “Ерөнхий мэдээлэл”, “Хяналт шалгалт шалгалтын асуудлууд, үнэлгээ”, “Тусгай тэмдэглэл буюу хяналт шалгалтаар авах арга хэмжээ, биелэлт”, “Гүйцэтгэлийн хяналт шалгалт”, “Тайлбар” гэсэн бүрэлдэхүүн хэсгээс бүтнэ.

Хоёр. Хяналтын хуудас хэрэглэх

2.1. Хяналт шалгалтыг эхлэхээс өмнө эрх бүхий албан тушаалтан шалгуулагч этгээдэд шалгалтын зорилго, бүрэлдэхүүнийг танилцуулж удирдамж, холбогдох хяналтын хуудасны нэг хувийг өгөх бөгөөд улсын /ахлах/ байцаагч албаны үнэмлэхээ үзүүлнэ.

2.2. Улсын /ахлах/ байцаагч нь хяналт шалгалт хийх явцад хяналтын хуудасны бүрэлдэхүүн хэсгүүдийг дараах байдлаар бөглөнө.

2.2.1. Ерөнхий мэдээлэл. Улсын /ахлах/ байцаагч нь энэ хэсэгт байгаа хяналтыг хэрэгжүүлэх байгууллагын нэр, шалгуулагч этгээдийн нэр, регистрийн дугаар, тухайн объектын нэр, хаяг, солбицол, байгуулагдсан огноо, үйл ажиллагааны чиглэл, дарга, захирал /иргэн, эрхлэгч/-ын нэр, холбоо барих утасны дугаар, хяналт шалгалт эхэлсэн, дууссан хугацаа, шаардлага хангасан, хангаагүй асуултын тоо, хууль сахин мөрдөлтийн хувь, эрсдэл үүсэх магадлалын хувийг тодорхой бөглөнө.

2.2.2. Хяналт шалгалтын асуудлууд, үнэлгээ. Энэ хэсэгт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт, үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ /цаашид “үйлдвэрлэл, үйлчилгээ” гэх/-ээс шалтгаалж хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгө, нийгмийн болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд сөрөг нөлөөлөл, учирч болзошгүй нөхцөл байдал үүсч болох асуудалд чиглэсэн асуудлууд, үйлдвэрлэл, үйлчилгээ нь хууль

тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг тэмдэглэх хэсэг, гүйцэтгэлийн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан эсэхийг тэмдэглэх хэсгээс тус тус бүрдэнэ.

2.2.3. Улсын /ахлах/ байцаагч нь тус журмын 2.2.2-т заасан хэсгийг дараах аргачлалын дагуу бөглөнө.

а. Хяналтын хуудсаар хяналт шалгалт хийхдээ “Хяналт шалгалт” хэсэгт тухайн шалгуулагч этгээдийн авсан оноог бөглөж, гүйцэтгэлийн шалгалт хийх үед “Гүйцэтгэлийн шалгалт” хэсгийг бөглөнө.

б. Улсын /ахлах/ байцаагч нь хяналт шалгалтын асуултуудын дарааллын дагуу бодит байдлыг газар дээр нь нухацтай шалгасны үндсэн дээр хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг үнэлж, үнэлгээг “Авсан оноо” хэсэгт асуулт бүрийн ард тэмдэглэнэ.

в. Шаардлага хангаж байгаа эсэхийг “тийм”, “үгүй”, “хамаарахгүй” гэсэн асуултаар үнэлэх ба “тийм” гэдэг хариулт нь “тийм, бий, нийцэж байна, хангалттай” гэсэн утгыг илэрхийлнэ, “үгүй, байхгүй, нийцэхгүй байна, хангалтгүй” гэсэн утгыг илэрхийлнэ, “хамаарахгүй” гэсэн хариулт нь “уг шаардлага тухайн шалгуулагч этгээдэд хамаарахгүй” гэсэн утгыг илэрхийлнэ.

г. Шалгуулагч этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээ нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа тохиолдолд батлагдсан 0 оноог “Авсан оноо” хэсэгт бөглөнө. Хангаагүй эсхүл дутуу хангасан тохиолдолд асуулт бүрд харгалзсан, батлагдсан оноог “Авсан оноо” хэсэгт бөглөнө. Харин тухайн шалгуулагч этгээдэд хамаарахгүй тохиолдолд харгалзах (-) тэмдгийг тавьж хяналтын хуудасны нийт онооноос хамаарахгүй хэсгийг хасаж хувийг тооцно.

д. Улсын /ахлах/ байцаагч хяналтын хуудасны асуулт бүрээр батлагдсан онооноос өөр оноо өгөхгүй.

е. Хяналтын хуудасны асуултуудыг бөглөж дууссаны дараа шалгуулагч этгээдийн үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхээс шалтгаалан эрсдэлийн их, дунд, бага түвшинд ангилна.

ё. Шалгуулагч этгээд нь хяналтын хуудасны нийт онооны 50 буюу түүнээс дээш хувьтай тэнцэх оноо авсан бол их эрсэдтэй буюу

хууль тогтоомж зөрчигдсөнөөс хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгө, хүрээлэн байгаа орчин, нийгмийн аюулгүй байдалд учруулж болзошгүй сөрөг үр дагавар үүсэх магадлал их; 30-49 хувьтай тэнцэх оноо авсан бол дунд эрсдэлтэй буюу хууль тогтоомж зөрчигдсөнөөс хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгө, хүрээлэн байгаа орчин, нийгмийн аюулгүй байдалд учруулж болзошгүй сөрөг үр дагавар үүсэх магадлал дунд зэрэг; 29 хувь буюу түүнээс бага хувьтай тэнцэх оноо авсан бол бага эрсдэлтэй буюу хууль тогтоомж зөрчигдсөнөөс хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгө, хүрээлэн байгаа орчин, нийгмийн аюулгүй байдалд учруулж болзошгүй сөрөг үр дагавар үүсэх магадлал бага гэсэн ангилалд хамааруулж үнэлээд, үнэлгээ хэсэгт шалгуулагч этгээдийн оноог, үнэлгээний хамт бичнэ.

ж. Хяналтын хуудасны оноо тавиагүй асуултын дагуу үйл ажиллагааг шалгахад тухайн мэдээлэл, баримт байхгүй, шаардлага хангаагүй тохиолдолд их эрсдэлтэй гэж үзэн хяналтын хуудасыг бөглөх шаардлагагүй.

2.2.4. хяналт шалгалт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтаар авах арга хэмжээ, биелэлт. Тухайн этгээдэд авах арга хэмжээ, биелэлтийг тэмдэглэх хэсгээс тус тус бүрдэнэ.

2.2.5. Улсын /ахлах/ байцаагч нь тус журмын 2.2.4-д заасан хэсгийг дараах аргачлалын дагуу бөглөнө.

а. Үнэлгээнээс хамааран иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хуульд заасан бүрэн эрх, үүргийнхээ хүрээнд улсын /ахлах/ байцаагчийн авах арга хэмжээг бичнэ.

б. Улсын /ахлах/ байцаагчийн шийдвэрийг шалгуулагч этгээд биелүүлсэн тухай тэмдэглэлийг “Биелэлт” хэсэгт бичнэ.

Гурав. Хяналтын хуудасны үнэлгээг баталгаажуулах

3.1. Улсын /ахлах/ байцаагч хяналтын хуудсаар шалгуулагч этгээдийг шалгаж дууссаны дараа хяналтын хуудасны “Баталгаажуулалт” хэсэгт өөрийн албан тушаал, овог нэрийг бичиж, гарын үсэг зурж, тэмдэг даран баталгаажуулсны дараа хяналтын хуудсыг шалгуулагч этгээдэд танилцуулна.

3.2. Шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтан хяналтын хуудасны үнэлгээ, авах арга хэмжээтэй танилцан албан тушаал, овог нэрээ бичиж, гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулна. Шалгуулагч этгээд хяналтын хуудасын үнэлгээтэй

танилцаж, хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд тайлбар бичнэ.

3.3. Улсын /ахлах/ байцаагч нь хяналтын хуудсаар тухайн байгууллагыг үнэлсэн үнэлгээ болон шалгалтын үр дүнгийн талаар хяналтын байгууллагын дээд шатны улсын байцаагчид тухайн шалгалт дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор танилцуулна.

3.4. Улсын /ахлах/ байцаагч хяналт шалгалтын нийтлэг журамд заасны дагуу хяналт шалгалтын бүртгэлийн нэгдсэн санд оруулна.

3.5. Улсын /ахлах/ байцаагч хяналтын хуудас, шалгалтын тэмдэглэлд үндэслэн хяналт шалгалтын дүнгийн тухай танилцуулга, бусад баримт бичгийг зохих журмын дагуу үйлдэнэ.

3.6. Баталгаажсан хяналтын хуудсыг 2 хувь үйлдэж, нэг хувийг шалгуулагч этгээдэд, үлдсэн хувийг бусад баримт бичгийн хамт тухайн хяналтын байгууллагын архивт хүлээлгэн өгнө.

АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАР,
ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ ГАЗАР